

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Засаг даргын зөвлөлийн хурал 3 удаа зохион байгуулагдаж, 7 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар 2022 оны 01 сарын 11-ний өдөр Говьсүмбэр аймагт ажиллаж аймгийн төвд шинээр баригдах цэвэрлэх байгууламж, дулааны станцын байршил, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, явцын байдалтай танилцлаа. Мөн аймгийн Засаг дарга Г.Батзам болон бусад албаны хүмүүстэй уулзаж “Бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих” төслийг дэмжин, хамтран ажиллах талаар санал солилцлоо.

Монгол Улсад Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан 2022 оны 01 сарын 12-ны өдөр Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар хамтран Үндэсний бөх, Үндэсний шагайн харваа, асуулт хариултын АХА тэмцээнийг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газраас "Улсын аварга малчин өрх"-өөр Баянтал сумын 2 дугаар багийн малчин Нацагдоржийн Баярсайхан, Сүмбэр сумын 6 дугаар багийн малчин Ганболдын Одсүрэн нар шалгарч, 2022 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр шагналыг гардуулан өгсөн.

Мөн аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журам”-д заасан шалгуурын дагуу аймгийн Засаг даргын зөвлөлийн 3 дугаар хурлаар хэлэлцэж, “Аварга малчин өрх”-өөр 6 өрх шалгарч, шагналыг 2022 оны 01 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд олгосон.

2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар коронавируст халдвараар өвчилсөн нийт иргэдийн тоо 6346, эдгэрсэн 6228, эмчилгээний тасагт эмчлэгдэж байгаа 158 иргэн байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын 1 дүгээр тунд 12705, 2 дугаар тунд 12073, 3-р тунд 5142, 4 дүгээр тунд 658 иргэн хамрагдаад байна.

### ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангах биелүүлэхэд анхааран ажиллаж байна.

2022 оны 01 дүгээр сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 760 751 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 932 951 мян.төгрөг төвлөрүүлж, 122 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогод 134 043 мян.төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 134 043 мян.төгрөг төвлөрүүлж, 100 хувь, сумын төсвийн орлогод 570 068 мян.төгрөг төвлөрүүлэхээс 570 068 мян.төгрөг төвлөрүүлж, 100 хувь, аймгийн төсвийн орлогод 56 640 мян.төгрөг төвлөрүүлэхээс 228 840 мян.төгрөг төвлөрүүлж, 404 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 656 байна.

**Статистикийн чиглэлээр:** Том малын зүй бусын хорогдлын ХАА-2, ХАА-н бүтээгдэхүүний үнийн ХАА-3, жимс жимсгэнэ тариалсан талбайн ургац хураалтын ХАА-5, ургац хураалт хадлан тэжээлийн ХАА-8, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнийн ХАА-10 мэдээг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн АҮ-1 мэдээ, барилга байгууламж объектын ББО-1, авто замын Т-1, радио телевизийн үйлчилгээний МХХ-5, худалдааны салбарын үнийн ХСҮ-1, ЗБ, ЗГ-н сарын мэдээ, Аялал жуулчлалын салбарын мэдээ, Мал эмнэлгийн мэдээ, НБХҮ-1 мэдээ, НҮ-1 мэдээ хэрэглээний бараа үйлчилгээний үнийн Үнэ-21 мэдээ, 7 хоногийн үнийн мэдээ мэдээллийг тус тус Үндэсний статистикийн хорооны төв серверт дамжуулсан. Аймгийн 2021 оны 12 сарын нийгэм эдийн засгийн танилцуулга болон хэвлэлийн бага хурлыг хугацаанд нь бэлтгэн нийтэлсэн.

**Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:** Аймгийн төсвийн болон орон нутгийн өмчит 77 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2021 оны 12 сарын байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 96.7 хувьтай байна.

## **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

### **Архивын тасаг:**

Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 4 хөмрөгийн 22 хадгаламжийн нэгжийн 910 хуудас, 490 заалт, 1253 хүний нэр, 468 байгууллагын нэр, 1409 газар зүйн нэр, 910 хуудас баримтыг программд холбосон.

2022 оны 01 дүгээр сард төрийн архиваас 9 иргэнд хуулбар, 2 иргэнд лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

### **Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан - 12
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 81
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 20
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 3
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 9
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 11
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 28

### **Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 8
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 22
- Гэрээний бүртгэл - 50
- Барьцааны гэрээний бүртгэл - 154
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 3

### **Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 9

### **Архивын чиглэлээр:**

- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар – 2

Нийт 417 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

**Цагдаагийн хэлтэс:** 2022 оны 01 дүгээр сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 138 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 35, зөрчлийн 103 гомдол мэдээлэл байна. Зөрчил гаргасан 53 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 33,275,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 98 хүнийг эрүүлжүүлж, 19 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 58 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын нутаг дэвсгэрт цагдаагийн эргүүлийг тасралтгүй зохион байгуулж, гудамж талбай, олон нийтийн газар болон авто замд зөрчил гаргасан 534 хүнийг 21,800,500 төгрөгөөр торгож, хүү торгуулийн орлогод төвлөрүүлсэн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, байгууллагын вэб хуудасны мэдээллийг шинэчлэн, "Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс" пэйж хуудас болон фэйсбүүк хуудсанд постер 20,

зурагт мэдээлэл 24, видео 13, анхааруулга, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг 234 удаа тус тус иргэд олон нийтэд хүргэсэн.

“Сар шинэ-2022”, “Мал, мах-2021” нэгдсэн арга хэмжээг орон нутагт зохион байгуулан болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт хийж 48 аж нэгж байгууллагад зөвлөмж сэрэмжлүүлэг өгч ажиллав. Баянтал, Шивээговь сумдад эргүүл, постуудыг ажиллуулж, гарал үүслийн бичиггүй мал, мах тээвэрлэж явсан 6 зөрчил илрүүлж, 900 нэгжээр торгох арга хэмжээ авсан байна.

**Шүүхийн шинжилгээний алба:** Хэргийн газрын үзлэгт 22 удаа оролцоноос хүний амь нас хохирсон 6, зам тээврийн ослын 3, хулгайлах гэмт хэрэг 2, бусад хэргийн газрын үзлэгт 11 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 260 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги:** Суллагдах хугацаа дөхсөн 11 хүмүүжигчийг “Нийгмийн халамжийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль” /шинэчилсэн найруулга/, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”, “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх тухай хууль”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль” зэрэг сэдвээр 9 удаагийн сургалтанд хамруулсан.

Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран иргэний үнэмлэх гээгдүүлсэн буюу дахин захиалах 11 хүмүүжигчийн торгуулийн мөнгө болох 30,000 төгрөгийг чөлөөлүүлж, иргэний үнэмлэх шинээр 2, гээгдүүлсэн буюу дахин авах 6, иргэний үнэмлэхний хугацаа дууссан 8 хүмүүжигчийн бичиг баримтыг захиалж, 6 хүмүүжигчид иргэний үнэмлэх олгогдсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвөөс гагнуурчин, засал чимэглэлийн мэргэжлийн сургалтад 35 хүмүүжигч хамрагдаж байна. 2022 оны 1 дүгээр сард төлбөрийн 132 гүйцэтгэх баримт бичгийн 3645468,3 мян.төгрөг төвлөрүүлэхээс 12 гүйцэтгэх баримт бичгийн 282690,9 мян.төгрөг төвлөрүүлж, бодит биелэлт 47.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Иргэний хүсэлтийн дагуу шинээр үйл ажиллагаа эрхлэх хоол үйлдвэрлэлийн газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, илэрсэн зөрчлийг үндэслэн 21 заалт бүхий хамтарсан зөвлөмж гаргаж хүргүүлэв.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Сүмбэр сумын 1-р багт үйл ажиллагаа явуулдаг Гаалийн хяналтын болон ачилт буулгалтын талбай бүхий 10 аж, ахуй нэгжийн 15 ажилтанд сургалт зохион байгуулсан.

Аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 4, хүнсний бүтээгдэхүүний 5, хоолны 11, нийт 20 сорьцонд 97 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэсэн. Шинжилгээний дүнгээр усны 4 сорьц нь 5 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй ба улсын байцаагчийн дүгнэлт гарган хүргүүлсэн.

**Онцгой байдлын газар нь:** Онцгой байдлын ерөнхий газар болон Ус, цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны мэдээ, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээ, сэрэмжлүүлэг, Галын аюулгүй байдлын талаарх мэдээг Онцгой байдлын газрын болон “go.nema.gov.mn”, “govisumber.gov.mn”, “Govisumbernews.mn” гэсэн сайтуудад байршуулж, иргэдэд мэдээ мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.

Гэр хорооллын айл өрх, худалдаа, олон нийт, үзвэр үйлчилгээний төвийн барилга байгууламжид “Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль”, “Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Онцгой байдлын газраас “Цагаан сар” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтад Сүмбэр сумын 1, 2, 3 дугаар багийн 455 айл өрх хамруулж, 310 зөрчил илрүүлэн газар дээр нь 26 зөрчлийг арилгуулж, 284 зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөмж өгч, 811 иргэнд галын аюулаас урьдчилан

сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгч, гарын авлага тараан тараах урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт зохион байгуулан ажиллав.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** 2021-2022 оны хичээлийн жилийн аймгийн Засаг даргын нэрэмжит “Чанарын үнэлгээний шалгалт”-ын дүн мэдээг нэгтгэж, зургаан шалгалтын 72 бүлгийн 1879 шалгуулагчийн материалд үнэлгээ хийж, 254 даалгаварт шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулсан.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах хүрээнд мэдлэг, авьяас чадвар, хичээл зүтгэлээрээ тэргүүлэн сурлага, спорт, урлаг болон бусад төрлөөр амжилт гарган манлайлсан “Оны онцлох хүүхэд” болон “Онцлох багш”-ийг шалгаруулж, урамшуулсан.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Монголын Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулсан барилдааныг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн зохион байгуулж, барилдаанд хүчит 64 бөх барилдсан.

Өмнөговь аймгийн Даланзадгад хотод зохион байгуулагдсан усанд сэлэлтийн насанд хүрэгчдийн 29 дэх удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээн аймгийн баг тамирчид оролцож, гурван хүрэл медаль, хоёр мөнгөн медаль хүртлээ.

Монголын Жюү жицүгийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотод 2022 оны 01 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, тус аймгаас өсвөрийн багийн 30 тамирчин оролцож, 4 алт, 2 мөнгө, 6 хүрэл, нийт 12 медаль авсан амжилтыг үзүүллээ.

Дорноговь аймгийн олон улсын хэмжээний мастер Жамъяаны Очирсүрэнгийн нэрэмжит өсвөр, үе, залуучуудын тэмцээнд “Жанжин Чойр” боксын холбооны тамирчид оролцож, 1 алт, 2 мөнгөн медаль хүртсэн амжилт үзүүллээ.

#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2021 оны 01 сар	2022 оны 01 сарын 20- ны байдлаар
Төрсөн эх	33	22
Гэрийн төрөлт	0	0
Амьд төрсөн хүүхэд	34	22
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	10	5
Эмнэлгийн нас баралт	1	2
Хоног болоогүй нас баралт	0	2
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	306	235
Амбулаторийн үзлэг	8400	3150
Халдварт өвчин	3	662

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр:** Тайлант хугацаанд 5 иргэнийг шинэ ажлын байранд зуучилж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

2018-2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдсан 37 иргэний 6122,0 мян.төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн. Тайлант хугацаанд 3906 иргэнд нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 79 өрхийн 412 гишүүнд 4552,0 мянган төгрөгийг олгосон.

***Ehajatj цахим системээр олгосон үйлчилгээ:***

- Нийгмийн халамжийн тэтгэвэр-237 иргэн
- Асаргааны мөнгөн тэтгэмж- 221 иргэн
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж-52 иргэн
- Жирэмсэн эхийн тэтгэмж- 128 иргэн
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж- 748 эх
- Насны хишгийн үйлчилгээг 711 иргэн
- Алдарт эхийн одонтой эхэд олгох мөнгөн тусламжийг 1359 иргэнд үзүүлсэн.

### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Аймаг дундын Малх отрын бүс нутагт 2 аймгийн 4 сумын 78 малчин өрхийн 40.1 мян.толгой мал буюу хонин толгойд шилжүүлснээр 56.7 толгой мал оторлож байна. Мөн отрын бүсээс гадна Төв, Дундговь аймгийн 16 өрхийн 18.4 мян.толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 27.5 толгой мал отроор өвөлжиж байна. Манай аймгаас Дорнод, Дорноговь, Хэнтий, Төв, Дундговь, Сүхбаатар аймагт нийт 22 өрхийн 17.3 мян.тол мал отроор өвөлжиж байна.

Аймгийн дүнгээр мах 135.65 тн буюу 81 хоног, гурил 70.5 тн буюу 51 хоног , сүү 3.2 тн буюу 1 хоног , төрөл бүрийн будаа 25 тн буюу 36 хоног , төмс 8.6 тн буюу 5 хоног , хүнсний ногоо 7.7 тн буюу 2 хоног, элсэн чихэр 7.2 тн буюу 16 хоног, давс 4.2 тн буюу 15 хоног, савласан ус 19.8 тн буюу 1 хоног, өндөг 1.4 тн буюу 5 хоног, ургамлын тос 3.9 тн буюу 12 хоногийн нөөцтэй байна.

#### **Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2022 оны 01 дүгээр сарын үнийн мэдээ**

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 10-500 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /цул/ 500 төгрөгөөр, үхрийн мах ястай 500 төгрөгөөр, хонины мах цул 500 төгрөгөөр, лууван 150 төгрөгөөр, төмс 150 төгрөгөөр, өндөг 10 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /12-р сараас /	
1	Үхрийн мах	Ястай	12500	10500	+500
		Цул	14000	13000	+500
2	Хонины мах	Ястай	8500	8000	-
		Цул	12000	11000	+500
3	Адууны мах	Ястай	8500	8000	-
		Цул	10000	9000	-
4	Ямааны мах	Ястай	7500	6500	-
		Цул	8500	8000	-
5	Лууван	Монгол	2400	2000	+150
		Хятад			
6	төмс	Монгол	1500	1200	+150
		Хятад			
7	Байцаа	Монгол	2000	1800	-
		Хятад			-
8	чинжүү	Монгол	13000	11000	+1500
		Хятад	13000	1100	
9	Манжин	Монгол	2000	1800	
		Хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	3800-	1500	-

11	Помидор	Монгол	13000	8000	-
12	Өргөст хэмх	Монгол	15000	12000	-
13	Элсэн чихэр	Монгол	3000	2300	-
14	Будаа	Цагаан задгай кг	3000	2400	-
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3450	3000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
16	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	4500	1150	-
18	Өндөг	Монгол	550	440	+10
19	Алтан гурил тарианы	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-
20	Ургамлын тос	Олейна	8800	7500	-
		Алтан	6500	4500	-

Малбн гоц халдварт шүлхий өвчний гаралт, тархалт улсын хэмжээнд намжмал байдалд шилжээгүй байгаатай холбогдуулан бусад аймаг, сумаас отроор орж ирсэн малчин өрх, малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналт, шалгалтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар Сүмбэр суманд 8 өрхийн 7240 тол.мал, Баянтал суманд 14 өрхийн 17558 тол.мал, нийт 22 өрхийн 24798 тол.мал байна. Эдгээр өрхүүдэд сумдын Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газраас бүрдсэн хяналт, шалгалтын хамтарсан ажлын хэсэг 2 удаа хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Мөн мал эмнэлгийн гоц халдварт өвчний сэрэмжлүүлэг мэдээг эмч нараар дамжуулан 290 өрхөд хүргээд байна.

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Сум дундын ойн ангийн харъяа Мод үржүүлгийн газрыг өргөжүүлэх зорилгоор БХНСАХЗ-аас 47.0 сая төгрөгөөр гүний худаг гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендер шалгаруулалтыг зарласан.

Сум дундын ойн ангитай хамтран 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “Хэрлэн гол”-ын дагуу байрлах 45 га талбайн байгалийн ойн сангийн 1 га талбайд унанги болон гэмтсэн мөчрийг цэвэрлэх ажлыг хийж, 7000 гаруй мөчир бэлтгэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/112 дугаар захирамжаар байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгаж, дүгнэлт гаргах байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Байгаль орчин, аялал, жуулчлалын яамаар төлөвлөгөө батлуулсан 9 аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын газраас биотехникийн арга хэмжээг зохион байгуулж тус арга хэмжээний хүрээнд 20 боодол өвс, 1 тонн хужрыг аргаль, хонь байршиж буй 6 байршилд тараан байрлуулсан.

Тайлант сард азотын давхар исэл (NO<sub>2</sub>) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO<sub>2</sub>) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 39 удаа, мөн шинжилгээг 39 удаагийн дээжинд хийж, дундаж азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.013 мкг/м<sup>3</sup>, сарын хүлцэх агууламж хэмжээ 0.200 мкг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн давхар исэл (SO<sub>2</sub>) 0.025 мкг/м<sup>3</sup> байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:** 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор газрын нэгдмэл сангийн тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлсэн.

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй 1150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын дотор засал, салхивчны ажил хийгдэж, заслын ажлын гүйцэтгэл 50 хувьтай, аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил гүйцэтгэлийн 98 хувьтай байна.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд нийт 3 858,937.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 8 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны явц 28.5 хувьтай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 8 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 3 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 13 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлаад байна. Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [govisumber.gov.mn](http://govisumber.gov.mn) сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрт цахим системд оруулан ажиллаж байна.

## ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

**Баянтал сум:** 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр сумын аж ахуй, нэгж байгууллагуудад Хөдөлмөрий тухай хуулийн шинэчилсэн найруулгаар цахим сургалт зохион байгуулж, 6 байгууллагын 102 ажилтан, албан хаагч оролцлоо.

Аймгийн “Өөдрөг” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай зөв ойлголт” сургалт зохион байгуулж, сумын удирдлагууд болон төрийн байгууллагын албан хаагчид, арилжааны банкны ажилтан зэрэг 17 албан хаагч оролцлоо.

**Шивээговь сум:** Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан 30 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан сумын ИТХ-аас “Иргэний Андгай өргөх ёслол”-ын арга хэмжээ, танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулсан.

Сумын Засаг даргын 2022 оны 01-р сарын 07-ны өдрийн А/01 дугаар Захирамжаар “Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах” ажлын хэсэг томилогдон цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, одоогийн байдлаар 426 иргэн хамрагдаад байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia системийн оператораас 56 нэр төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. 2021 онд нийт 425 иргэнд үйлчилгээ үзүүлж, 309200 төгрөгийг тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлсэн.

“Эрүүл мэндийн боловсрол олгоё” цахим хуудас нээж иргэдэд эрүүл мэндийн талаарх мэдээ мэдээллийг тасралтгүй оруулж, мэдээллээр ханган ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн 2021 оны эргэн төлөлтийн төлөвлөгөө 43,031,700 төгрөг төвлөрүүлэхээс 46,444,699 төгрөг төвлөрч зээлийн эргэн төлөлт 107,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумын харьяалалгүй ахмад настнуудыг аж ахуйн нэгж байгууллагад харьяалуулах ажлыг зохион байгуулж, сумын хэмжээнд нийт 265 ахмад настнаас 247 ахмад настан буюу 93,2 хувийг суманд үйл ажиллагаа явуулдаг 42 аж ахуйн нэгж, байгууллагад харьяалуулаад байна.

Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Нийтийн их цэврэлгээ зохион байгуулах тухай” А/35 дугаар захирамжийн дагуу нийтийн их цэврэлгээг 2022 оны 01 сарын 21, 22-нд зохион байгуулж, нийт 23 аж ахуй нэгжийн 99 иргэн оролцож 4,8 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар захирамжаар агаар бохирдуулагчдын эх үүсвэрийн тооллогын ажлыг зохион байгуулж, нийт 97 айл өрхөөс судалгаа авахад 465.5 тн нүүрс, 18мкв мод жилд хэрэглэж байна гэсэн байна.

**Сүмбэр сум:** Цэргийн шинэчилсэн бүртгэлийг Аймгийн Засаг даргын А/1 дүгээр захирамжийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 10-27-ны хооронд зохион байгуулж ажиллаж сумын хэмжээнд 3032 иргэн бүртгэгдэхээс 44.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хамтарсан багт гэр бүлийн хүчирхийллийн дуудлага 12 бүртгэгдсэн бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээг хийж аймгийн Цагдаагийн хэлтэст 7 тохиолдлыг шилжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 2 тохиолдлыг хамруулсан.

2021 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр шинээр мянгат малчин 7-оор нэмэгдсэн байна.

2022 оны 1 сарын 25-ны өдрийн байдлаар сум хөгжүүлэх сангаас зээл авсан 2 зээлдэгч зээлээ бүрэн төлж барагдуулан, 2 зээлдэгч зээлийн эргэн төлөлт хийж, 35,7 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрсөн байна. Одоогоор сум хөгжүүлэх сангийн дансанд нийт 384,7 сая төгрөг төвлөрөөд байна.

Хөдөөгийн 5 дугаар багийн нутаг Дунд уул, Дарь эх, Цоорхойн рашаан зэрэг газруудад цэвэрлэгээ хийж, 4 тонн хог хаягдлыг цэвэрлэлээ.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**